



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/815

Булган сум

Агентлаг, байгууллагын дарга нарын 2025 оны
гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэсэн тухай

Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2, 52.3 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.9, 4.10, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулах олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2, 2.3, 2.4 дэх хэсэг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга, агентлагуудын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээг хавсралтаар баталсугай.

2.Үнэлгээнд үндэслэн журмын дагуу батлагдсан төсөвтөө багтаан урамшуулал олгохыг Аймгийн Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Байгаль орчны газар, Худалдан авах ажиллагааны газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг 2025 оны 12 дугаар сарын 26-ны дотор баталгаажуулахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Насанжаргал)-т даалгасугай.

4.Гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэсэн байдалд дүн шинжилгээ хийж, 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг оны эхнээс заалт тус бүрээр хяналтад авч, биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцож тайлагнахыг агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Сурвалж Ажил 2025 өдөр бүр 6325011242

Аймгийн Засаг даргын 2025 оны
12 дугаар сарын 25-ны/ний өдрийн
А/819 дугаар захирамжийн хавсралт

АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАРЫН 2025 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

д/д	Агентлаг, байгууллагуудын нэрс	Үнэлгээ хувиар
1	2	3
1	Аймгийн Засаг даргын тамгын газар	91.8
2	Орон нутгийн өмчийн газар	84.4
3	Эрүүл мэндийн газар	80.0
4	Биеийн тамир, спортын газар	85.6
5	Хүнс, хөдөө аж ахуйн газар	89.1
6	Байгаль орчны газар	81.7
7	Худалдан авах ажиллагааны газар	85.0
8	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	72.0
9	Онцгой байдлын газар	87.9
10	Цагдаагийн газар	90.6
11	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	24.7
12	Татварын газар	83.8
13	Улсын бүртгэлийн хэлтэс	87.6
14	Боловсролын газар	77.5
15	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	77.0
16	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	88.3
17	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	81.7
18	Нийгмийн даатгалын газар	83.4
19	Мал эмнэлгийн газар	83.0
20	Статистикийн хэлтэс	85.5
21	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	88.4
22	Шүүхийн шинжилгээний хэлтэс	88.9
23	Стандарт, хэмжилзүйн хэлтэс	90.6
24	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	10.6
25	Ус цаг уур, орчны шинжилгээний төв	74.2
26	"Булган Мээж" ОНӨХХК	85.0